



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 24

Дугаар 01

Улаанбаатар хот

“Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Д.Оюун даргалж, хувьцаа эзэмшигч Б.Зориг /768606/, Д.Тунгалаг /99192/, Д.Оюун /1279/, Д.Төмөр-Очир /5/, Ж.Энхмаа /2/, Ж.Энхтунгалаг /1/, Б.Ганболд /1/, “Ариг гал ХК /57/” түүнийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Бэхбат нарыг оролцуулан, хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуунаар хөтлүүлэн “Материалимпэкс” ХК-ийн хурлын танхимд 2026 оны 04 сарын 24-ний өдрийн 10 цаг 45 минутад хийв.

Ашигласан цахим хаяг: ZOOM-meeting 867 4700 3067. Цахимаар оролцсон хувьцаа эзэмшигч байхгүй. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүд бүрэн оролцов.

Даргалагчаас: Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлээд, ХЭ-ийн ээлжит хурлын дэгийг танилцуулаад хурлын материалтайгаа харьяа брокер дилерийн компаниараа дамжуулан авсан байх. Компани дээр биечлэн ирж танилцах хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигч байхгүй болохыг тэмдэглэлд тусгуулъя.

Хурлаа эхлүүлэхээс өмнө тооллогын комиссын гишүүдээ танилцуулъя гээд Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэл нягтлан бодогч мэргэжилтэй, “Материалимпэкс” ХК-ийн нягтлан бодогч ажилтай, П.Сумьяасугар тус компанийн Гадаад харилцаа, тээвэр ложистикийн хэлтэст тээврийн менежерээр ажилладаг, эдгээр 2 гишүүн маань манай компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдтэй ямар нэгэн садан төрлийн холбоогүй, манай компанийн хувьцаа эзэмшдэггүй, тооллогын комиссын гишүүн П.Сувдаа тус компанийн эрүүл ахуйчаар ажилладаг, тооллогын комиссын гишүүд бүгдээрээ манай компанийн хувьцаа эзэмшдэггүй. Эдгээр хүмүүс өнөөдрийн хурлын тооллогын комиссоор томилогдсон байна. Одоо цаг 10 цаг 45 минут болж байна, комиссын дарга, гишүүд ирцийн бүртгэлийг дуусгаж, ирцийн мэдээгээ танилцуулъя.

Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч нэгбүрийн итгэмжлэл, биеийн байцаалтыг шалгаж, тулгалт хийв. Ирцийн ажиллагаа 10:00 цагаас эхэлсэн болно.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Ирцийн мэдээллийг хуралд танилцуулж, 869,143 ширхэг саналын эрх бүхий хувьцаатай 8 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна. Ирцийн дүн 6,52% байна гэв.

Даргалагчаас: Саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцох хууль зүйн үндэстэй байна. Хурлын дараалал, хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- Тооллогын комисс ирцийн бүртгэлээ хийж, ирцийн мэдээгээ танилцууллаа
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн 2026-2029 онд ажиллах ердийн болон хараат гишүүдийн танилцуулга
- ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсөв, гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, батлах
- Ногдол ашгийн талаарх мэдээлэл сонсох

- Баянхошуу дэд төвийн хүрээнд СХД-ийн 5-р хорооны нутаг дэвсгэр, Ханын материал орчмын төслийн танилцуулга, энэхүү төслийн хүрээнд хийгдэх, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох
- 2022-2025 онд компаниас хэрэгжүүлсэн барилгын төслүүдийн талаарх танилцуулга, мэдээлэл
- Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт, хариултыг хэлэлцэх асуудал тус бүрээр тухай тухайн үедээ асууж болно.

- Тооллогын комиссоос, саналын хуудсыг бөглөх зааврыг өгч санал хураалт явагдана.
- Саналын хуудас тоолох явцад хурал түр завсарлана.
- Тооллогын комиссоос саналын хуудасны дүнг танилцуулна.
- ХЭХ-аас гарах тогтоолыг танилцуулж, батлуулна.
- Хурлыг хаана. Ийм дарааллаар өнөөдрийн хурал явагдана.

Хэлэлцэх асуудлын дараалал болон бусад асуудлаар хувьцаа эзэмшигчдэд асуух болон хэлэх санал хүсэлт байна уу? Хурлын материалыг Монголын Хөрөнгийн Биржийн сайтад байршуулсан, үнэт цаасны компаниуд руу мэйлээр явуулсан. Өнөөдөр сонинд 2026.03.16 ба 2026.03.31-ний өдрүүдэд хурлын зар байршуулсан байгаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг нийтэд мэдээлснээс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд компани дээр хурлын материалыг хэвлэж бэлдсэн байсан боловч хэн ч ирж танилцаагүйг түрүүн хэлсэн. Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлаас өмнө шаардлагатай материалтайгаа ирж танилцах бүрэн боломж үргэлж нээлттэй байдаг гэдгийг дахин хэлье. Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэн хэлэлцэх асуудал тус бүрт чөлөөтэй, идэвхтэй асууж, хариулж, сонирхсон бусад зүйлсээ минут харгалзахгүйгээр чөлөөтэй асууж болно.

Оролцогчид: Дараалал, хурлын дэгтэй холбоотой саналгүй, асуулт хариултын журмаар явуулахыг дэмжиж байна гэцгээв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлын дарааллын талаар асуух асуулт байхгүй бол нэг дэх асуудалдаа орё. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг миний бие хэлэлцүүлнэ. /ТУЗ-ийн дүгнэлтийг хавсаргав/.

Даргалагчаас: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор асуух асуулт байвал хэдийд ч тавьж болно шүү. ТУЗ-ийн дүгнэлттэй холбоотой асуух асуулт байна уу?

Б.Ганболдоос: Аялал жуулчлалын компанийн хувьд юу билээ? Жуулчны баазтай билүү?

Д.Оюунаас: 200 оны эхэн үед манайх Монголиан импери турс ХХК-ийг үүсгэн байгуулахдаа гадаадын жуулчдыг дотооддоо аялуулах зорилготой байсан. Энэ хүрээнд Хөвсгөл аймгийн Эрхэл нуурийн эрэгт нэг жуулчны бааз худалдан авч байсан боловч шувууны ханиад энэ тэр гээд гаднаас жуулчин авч чадаагүй, хэдэн жил болоод жуулчны баазаа зарсан. Одоо манайд жуулчны бааз гэж байхгүй. Зөвхөн Монгол Улсаас гадагшаа чиглэсэн аялал зохион байгуулж байгаад 2026 оны 1 сарын 01-нээс үйл ажиллагаагаа зогсоосон байгаа. Учир нь ашигтай ажиллах боломжгүй байсан учраас үйл ажиллагаагаа зогсоосон.

Б.Ганболдоос: Арматур дотоодоос худалдан авалт хийсэн гэж байна. Хаанаас авсан бэ?

Д.Оюунаас: 130 тонн орчмыг л авсан. Манай компанид байхгүй размерыг худалдан авагчаас захиалсан тохиолдолд өөр газраас авч өгдөг тохиолдол байдаг. Бид хамтын ажиллагаа, тухайн арматурын чанарг харгалзан “Ганрекс” ХХК-иас авсан.

Ж.Энхтунгалагаас: БҮК арматур үйлдвэрлэдэг билүү?

Б.Зоригоос: Үйлдвэрлэдэггүй гэв.

Ж.Энхтунгалагаас: Баянхошуу дэд төвийн төсөл хэзээ эхлэх вэ?

Даргалагчаас: Энэ асуудал хэлэлцэх асуудлын 10 дугаарт байгаа учраас тэр үед тодорхой мэдээлэл авах боломжтой.

Оролцогчид: Өөр асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Дараагийн хэлэлцэх асуудал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцүүлье. /дүгнэлтийг хавсаргав/. Асуух асуулт байгаа эсэхийг тодруулахад

Ж.Энхтунгалагаас: Баянгол дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрийн төсөлд оролцсон билүү?

Б.Зоригос: Манай байгууллага Этүгэн тэнгэр констракшн ХХК-тай түншлэлээр хамтран 4 багцын сонгон шалгаруулалтад оролцсон бөгөөд зөвхөн нэг багцад шалгарсан. Бидний түншлэлийн зорилго 4 багцад хамтран ажиллах байсан боловч нэг багцад шалгарч, Этүгэн тэнгэр констракшн ХХК энэхүү нэг багцыг манай байгууллага дангаараа хэрэгжүүлбэ гэсэн саналыг бид зөвшөөрсөн. Гэсэн хэдий ч батламжид хамтарсан нэр бичигдсэн учраас манай нэр яваад л байдаг. Тухайн төслийн хувьд Этүгэн тэнгэр констракшн ХХК бүх асуудлыг дангаар хариуцахаар тохиролцсоныг бил иргэд, оршин суугчдын хэд хэдэн уулзалт болон иргэдээс асуусан асуултад тайлбарлаж, ОСБГ-т ч албан ёсоор тайлагнаж, тайлбарлаж ирсэн. Тодорхойгүй шалтгаанаар Этүгэн тэнгэр констракшн ХХК шалгарсан төслөө хугацаанд нь амжилттай хэрэгжүүлж чадаагүй тул 2025 онд төслийн сонгон шалгаруулалтад шалгарсан компанийг цуцалсан. Иймд одоо энэ төсөлтэй холбоотой асуудал байхгүй гэсэн үг гэв.

Оролцогчдоос: Нэмж асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг гүйцэтгэх захирал Б.Зоригос хэлэлцүүлбэ.

Б.Зоригос: Өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2025 оны төлөвлөгөөг товч бөгөөд тоон үзүүлэлтгүй байна гэсэн шүүмжийг авсан учраас энэ жил алдаагаа засахыг хичээсэн. Бид аль болох бодитоор төлөвлөхийг хичээдэг гэж 2026 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлэв /Бизнес төлөвлөгөөг хавсаргав/.

Б.Зоригос: Бизнес төлөвлөгөөнөөс асуух асуулт байна уу?

Оролцогчид: Асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлынхаа дараалал ёсоор ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулгыг нарийн бичгийн даргаас хэлэлцүүлбэ.

Т.Лхагвачулуунаас: Ердийн болон хараат бус гишүүнд нэрээ дэвшүүлсэн нэр дэвшигчдийн танилцуулгыг дэлгэрэнгүй /дэлгэцээр/ танилцуулаад асуух асуулт байгаа эсэхийг асуухад

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсөв, гишүүн, дарга, нарийн бичгийн даргын цалин урамшууллын тухайд өмнөх жилээс өөрчлөлт байхгүй. Бичиг хэрэг, хурлын зартай холбоотой бусад төсөвт 5,000,000 төгрөг, ТУЗ-ийн нэг гишүүний нэг сарын цалин 1,000,000 төгрөг, ТУЗ-ийн дарга нэмэгдэл 3,000,000 төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 1,500,000 төгрөг, комплайнсын ажилтан 500,000 төгрөг гэж Цалин урамшууллын хорооноос ирүүлсэн саналыг оруулж байна.

Оролцогчид: Асуух асуулт байхгүй гэв. /ЦУХорооны саналыг хавсаргав/

Даргалагчаас: Дараагийн хэлэлцэх асуудал Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох байгаа. Улаанбаатар хотод СЗХ-ны тусгай зөвшөөрөл бүхий 178 аудитын байгууллага байна. Үүнээс бид тэрийг энийг гэх боломжгүй, хувьцаа эзэмшигчид өнөөдөр 178 байгууллагын талаар танилцах боломжгүй учраас бид дурын 5 байгууллагаас аудитын гэрээ хийх үнийн санал авсан. Бид ямар ч аудитын байгууллагыг сонгосон хөндлөнгийн аудит учраас тухайлан нэрлэх, тусгайлан танилцуулах боломжгүй. Иймд бид хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Координат про консалтанте аудит” ХХК-ийн танилцуулгыг мэдээлж байна. Аудитын тусгай зөвшөөрөл бүхий 178 байгууллагын нэр хаяг, утасны дугаар бүхий жагсаалт та бүхний өмнө байгаа. Ямар байгууллагыг сонгох нь эрхэм хувьцаа эзэмшигч та бүхний сонголт учраас энэ асуудлыг ингээд нээлттэй үлдээ. Асуух асуулт, санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй, тусгайлсан саналгүй гэв.

Даргалагчаас: Бас нэг зүйлийг тодруулан хэлэхэд Аудитын тухай хууль өөрчлөгдсөнтэй холбоотой аудитын байгууллагуудын үйл ажиллагаа, хяналт арай өөрчлөгдсөн. Мөн аудиторчуудын маань чадвар, чадамж хэр байгааг хараахан мэдэх боломжгүй байна. Манай компанийн үйл ажиллагаанд тохирсон, зөвлөмж зөвлөгөө сайн өгдөг, хөндлөнгийн байр сууриа тогтвортой хадгалдаг гэх мэтчилэн шалгуурыг хангасан байгууллагыг цаашид олж тогтоох, судлах ажлыг хийх шаардлагатай юм байна гэж өмнөх жилийн судалгаанаас дүгнэсэн. Координат про консалтантс аудит гэдэг нь Координат аудит гэж байсан юм байна лээ. Манай ХК-ийн аудтыг хийж байсан газар. Нэр нь өөрчлөгдсөн байгааг тодруулан хэлж байна.

Даргалагчаас: 2025 оны МИХК-ийн үйл ажиллагааны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 150 төгрөг төлөхөөр ТУЗ-ийн 06 тоот тогтоол 2026.02.06-нд гарсан. 2024 онд мөн нэгж хувьцаанд 150 төгрөгийн ногдол ашиг тарааж байсан. 2024 болон 2025 оны компанийн цэвэр ашгийн хэмжээ ижил учраас ижил дүнгээр ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн. Ногдол ашгийг 2026.04.30-ны дотор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээгээ хийгээд ногдол ашгаа тараана

Ж.Энхтунгалагаас: 2024 онд ногдол ашиг тараасан билүү?

Даргалагчаас: Тараасан, нэгж 150 төгрөгөөр тараасан.

Даргалагчаас: Асуух асуулт, тодруулах зүйл, санал, хүсэлт алийг нь ч хэлэлцэж буй асуудлын аль ч үед асууж, хэлж ярьж болно шүү. Жил бүр уламжлал болон хийгддэг, дандаа ирдэг хувьцаа эзэмшигчид маань ирсэн болхоор асуух асуултгүй байх шиг байна.

Улаанбаатар хотод хэрэгжүүлэх 24 мега төслийн нэг болох Баянхошуу дэд төвийн хүрэн дэх СХД-ийн 5-р хороо, Ханын материал орчмын төслийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг Т.Лхагвачулуунаас мэдээлэл өгье.

Т.Лхагвачулуунаас: Тус компани Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн орон сууцны корпораци ХК-иас зарласан дээрх төслийн сонгон шалгаруулалтад оролцож, 2025.09.15-ны өдөр Батламжаа албан ёсоор гардан авсан. Энэхүү төсөлд оролцохдоо Материалимпэкс ХК-ийн охин компани болох барилгын тусгай зөвшөөрөл бүхий Материалимпэкс констракшн ХХК, байнгын хамтын ажиллагаатай, гэхдээ харилцаа хамааралгүй зураг төслийн компани “Кон консалтинг” ХХК-тай хамтран оролцсон. Угаасаа төсөлд оролцох шаардлага нь ч ийм байсан тул 3 компани түншлэлээр оролцогч, Материалимпэкс ХК-ийн түншлэлд гэж батламж гарсан.

Энэхүү төсөл нь 12,6 га газарт хэрэгжих 1800 гаруй айлан орон сууц, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, эмнэлэг зэрэг цогцолбор хотхон бөгөөд Улаанбаатар хотын томоохон төслүүдийн нэг мөн. Бид Нийслэлийн орон сууцны корпораци ХК-тай гэрээ хэлцлээ 2025 онд хийж, 2026 оны 03 дугаар сараас барилгын бэлтгэл ажлуудаа хийгээд ажлыг эхлүүлэхэд бэлэн болсон. Төслийн барилгын талбайдаа хашаа хороогоо барьж, техник хэрэгслүүдээ угсарч, зөөврийн бетон зуурмагын үйлдвэр шинээр барьж, барилгын ажлыг эхлүүлэхэд бэлэн болоод байгаа. Харин НОСК ХК газрын асуудал буюу 5 айлын асуудал газар чөлөөлөлттэй холбоотой үлдээд байгаа учраас газрын гэрчилгээгээ өөр дээрээ гаргуулж авч чадаагүйгээс техникийн нөхцөлүүд гарах боломжгүй болж ажил багахан удаашралтай болсон. Гэхдээ энэ байдал тун удахгүй арилах байх гэж бид найдаж байгаа. Манай компани өөрийн зүгээс авах бүхий л бэлтгэл ажил, ИТА, техник хэрэгсэл, шороо ухах, зөөвөрлөх талбай зэрэг бүхий л бэлтгэл ажлыг бэлэн болгосон. Техникийн нөхцөлүүд гарснаар дараа дараагийн ажлууд ундарч, төлөө бол 05 сарын 10-наас нэг их оройтохгүйгээр эхлэх байх гэж найдан хүлээлттэй байгаа. Гэхдээ энэ хугацаанд бид зүгээр хүлээгээд байгаа зүйл байхгүй, ажилчдын түр байр, оффисын түр сууц, нойлын асуудал зэрэг бэлтгэл ажлуудаа тасралтгүй хийсээр байгаа. Төслийн хувьд захиалагч нь НОСК ХК, газраар хөрөнгө оруулж, манай компани төслийг хэрэгжүүлэх юм гэж ойлгож болно. бид энэ төслийг амжилттай хийж чадна гэж итгэж байна гэв.

Даргалагчаас: Төсөлтэй холбоотой нэмж асуух асуулт байна уу?

Оролцогчид: Байхгүй, мэдээлэл авсан гэв.

Даргалагчаас: Нэгэнт энэ төсөл яригдсан байгаа учраас их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар хуулийн мэргэжилтэн Т.Лхагвачулуунаас хэлэлцүүлнэ.

Т.Лхагвачулуунаас: Энэ төслийн төсөвт өртөг эцсийн байдлаар хараахан батлагдаагүй байна. Гэсэн хэдий ч нийт барилгажих талбай 12.6 га гэдэг бол маш том талбай. Орон сууцны жижиг дүүргийн дайны хороолол, цогцолбор баригдах юм. Энэ хэмжээний том төслийг манай ХК дангаараа хэрэгжүүлэх боломжгүй. Төслийн ерөнхий хугацаа 8 жил, одоогийн байдлаар. Богино хугацаанд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай учраас гадаадын болон дотоодын иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч бид энэ төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай нь ойлгомжтой. Иймд их хэмжээний хэлцэл, одоогийн байдлаар тоо хэмжээ заах боломжгүй, Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.1-д “Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна” гэж заасны дагуу зөвхөн энэхүү төслийн хүрээнд хийгдэх их хэмжээний хэлцэл хийх эрхийг Төлөөлөн Удирдах зөвлөлд олгоно уу гэж хувьцаа эзэмшигчдээсээ хүсэж энэ хурлаар хэлэлцүүлж байна.

Мөн энэ төслийг түншлэлээр хэрэгжүүлж байгаа гэж хэлсэн. Үүнтэй холбоотой компанийн охин компани болох Материалимпэкс констракшн ХХК, Материал кредит ББСБ, хамаарал бүхий компани болох “Гермес” ХХК, “Материал гласс” ХХК, “Материал проперти” ХХК-иудтай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрхийг мөн ТУЗ-д олгож өгнө үү.

Тодруулбал, Материалимпэкс констракшн ХХК бол 16 давхар барилга барих тусгай зөвшөөрөлтэй, Материал кредит ББСБ /санхүүгийн яаралтай хэрэгцээг шийдвэрлэх боломжтой/, “Гермес” ХХК ИТА, техник хэрэгслээр мөн өмнөх төслийн хөрөнгө оруулалтыг энэ төсөл татан шилжүүлэх, “Материал гласс” ХХК вакуум цонх хаалга, хаалт, гадна шилэн фасадны ажил хийх үүрэгтэй, “Материал проперти” ХХК төслийн борлуулалт, бараа материалын татан авалтад оролцох үүрэгтэй. Эдгээр чиг үүргийн хүрээнд болон бусад чиг үүргээр Баянхошуу дэд төвийн Ханын материал орчмын сонгон шалгарсан төсөлд хамтран оролцох, гэрээ хэлцэл хийх, ажил үүрэг гүйцэтгүүлэх, оруулсан хөрөнгө оруулалтыг хооронд нь шилжүүлэх, хөрөнгө оруулалт өгөх, авах зэргээр сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдэх учраас энэ эрхийг ТУЗ-д олгож өгнө үү гэв.

Даргалагчаас: Төслийн мэдээлэлтэй холбоотой, их хэмжээний хэлцэл хийх, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгохтой холбоотой асуух асуулт, санал байна уу?

Оролцогчид: Байхгүй дэмжиж байна гэв.

Даргалагчаас: ХЭХ-аар хэлэлцэж, батлах асуудлууд ерөнхийдөө үүгээр дуусч байна. Одоо нийтээр нь сонсоод асуух зүйл гарсан байж магадгүй. Хэлэлцсэн асуудалтай холбоотой асуулт, санал, хүсэлт аль нь ч байж болно.

Оролцогчид: Байхгүй, тухай бүрт тодруулж асуусан гэв.

Даргалагчаас: Санал хураалт дууссан бол санал хураалтдаа оръё. Тооллогын комиссоос саналыг хуудсыг тараая. Дэлгэц дээр саналын хуудас бөглөх заавар, жишээ гарсан байгааг анзаарч, сайн уншиж байгаад шаардлагатай бол тооллогын комиссын гишүүдээс асууж байгаад бөглөөрэй.

Тооллогын комиссын гишүүдээс хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас тарааж, бөглөх зааврыг танилцуулав.

Санал хураалт 12:25 цагт эхлэв.

Хурал 12:25 цагт завсарлаж, хурал 12:40 цагт үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Тооллогын дүнгийн тухай комиссын 01 тоот тогтоол уншиж танилцуулав. Утга нь:

1. Саналын хуудаснуудаас 869,143 саналын эрх бүхий 8 саналын хуудсыг хүчинтэйд тооцсугай.

2. Хүчингүйд тооцсон саналын хуудас байхгүй болохыг дурдсугай.

3. Хүчинтэйд тооцсон саналын хуудсаар өгсөн санал хураалтыг тоолоход хэлэлцүүлж буй асуудлыг доорх хувиар зөвшөөрснийг тогтоосугай. Үүнд :

3.1 Компанийн 2025 үйл ажиллагааны болон санхүүгийн байдалд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлахыг зөвшөөрсөн баталсан – 100%;

3.2 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг батлахыг зөвшөөрсөн – 100%;

3.3 Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн – 100%;

3.4 Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгосон хувь:

3.4.1 Ердийн гишүүн Б.Зориг – 869,142 буюу 63,5%

3.4.2 Ердийн гишүүн Д.Оюун – 869,142 буюу 63,5%

3.4.3 Ердийн гишүүн Н.Түмэндэмбэрэл – 1339 буюу 0,097%

3.4.4 Ердийн гишүүн П.Сувдаа – 869,085 буюу 63,5%

3.4.5 Ердийн гишүүн Э.Пүрэвсүрэн – 869,142 буюу 63,5%

3.4.6 Ердийн гишүүн Ш.Ганзориг – 769,945 буюу 56,2%

3.4.7 Ердийн гишүүн Э.Гүнчинсүрэн – 0

3.4.8 Ердийн гишүүн Д.Оюунчимэг – 99,254 буюу 7,2%

3.4.9 Ердийн гишүүн Н.Мягмарсүрэн – 867,803 буюу 62,6%

3.4.10 Хараат бус гишүүн Б.Онон – 1340 буюу 0,099.%

3.4.11 Хараат бус гишүүн Ч.Энхтуул – 1339 буюу 0,097%

3.4.12 Хараат бус гишүүн С.Цэнгэлмаа – 867,806. буюу 63,4%

3.4.13 Хараат бус гишүүн П.Алтанцэцэг – 867,803 буюу 63,4%

3.4.14 Хараат бус гишүүн М.Марат – 869,139 буюу 63,5.%

3.5 ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсөв, гишүүд, нарийн бичгийн даргын цалин урамшууллын хэмжээг батлахыг зөвшөөрсөн – 100%;

3.6 Хөндлөнгийн аудитын байгууллагаар

3.6.1 “Координат про консалтантс аудит” ХХК-ийг сонгосон – 100%;

3.7 Баянхошуу дэд төвийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэр дэх 12.6 гар талбарт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн, орон сууцжуулах төсөлтэй холбоотой сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх эрх олгохыг зөвшөөрсөн – 100%.

Даргалагчаас: Тооллогын комиссын дүн, тогтоолтой холбоотой асуух асуулт байна уу?
Оролцогчдоос: Байхгүй гэв.

Даргалагчаас: Тооллогын комиссын тогтоолыг үндэслээд өнөөдрийн ХЭХ-аас дараах тогтоолууд гарч байна. Тогтоол №01 утга:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01-ээр, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02-оор, Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталсугай.

2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган, эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгасугай.

3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгосугай.

Тогтоол №02. Утга:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн

1.1 Ердийн гишүүнээр:

- 1.1.1 Б.Зориг
- 1.1.2 Д.Оюун
- 1.1.3 П.Сувдаа
- 1.1.4 Э.Пүрэвсүрэн
- 1.1.5 Ш.Ганзориг
- 1.1.6 Н.Мягмарсүрэн нарыг,

1.2 Хараат бус гишүүнээр:

- 1.2.1 С.Цэнгэлмаа
- 1.2.2 П.Алтанцэцэг
- 1.2.3 М.Марат нарыг тус тус сонгосугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хууль болон бусад холбогдох дүрэм, журамд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг үүрэг болгосугай.

Тогтоол №03. Утга:

1. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны нийт төсвийг **173,000,000 /Нэг зуун далан гурван сая/** төгрөгөөр баталсугай.

2. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн цалин хөлсийг дараах байдлаар тогтоосугай:

2.1.Ердийн болон хараат гишүүн 1,000,000*9 /сар бүр, гишүүн тус бүр/ төгрөг;

2.2.Нарийн бичгийн дарга 1,500,000 /сар бүр/ төгрөг;

2.3.Ажил албан тушаал хавсран гүйцэтгэх нэмэгдэл /Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга/ - 3,000,000 /сар бүр/ төгрөг;

2.4.Албан тушаал хавсран гүйцэтгэх нэмэгдэл /комплайнсын ажилтан/ - 500,000 /сар бүр/ төгрөг.

3. Ажлын онцлогийг харгалзан Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын урамшуулал, нэмэгдэл цалин хөлсийг сар бүр /сар бүрийн 5 ба 20-ны өдрүүдэд/, бусад гишүүдийн урамшууллыг улиралд нэг удаа олгосугай.

4. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин хөлс, урамшуулал, нэмэгдэл цалин хөлснөөс хуульд заасан шимтгэл, татварыг тухай бүр суутган олгосугай.

Тогтоол №04. Утга:

1. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, аудитын дүгнэлт гаргах байгууллагаар Монгол Улсын “Координат Про Консалтантс аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Координат Про Консалтантс аудит” ХХК-тай гэрээ байгуулах, ажлын хөлсний хэмжээг тохиролцох эрхийг тус компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлд олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг хууль, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн Удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

Тогтоол №05. Утга:

1. Нийслэлийн Баянхошуу дэд төвийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэр дэх 12.6 гар талбарт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн, орон сууцжуулах төсөлтэй холбоотой “Материалимпэкс” ХК-ийн охин компани болох “Материалимпэкс констракшн” ХХК, “Материал кредит ББСБ” ХХК, харилцаа хамаарал бүхий компани болон “Гермес” ХХК, “Материал Гласс” ХХК, “Материал проперти” ХХК-иудтай хамтран ажиллах, хөрөнгө оруулах, хөрөнгө татах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрхийг Төлөөлөн Удирдах зөвлөлд олгосугай.
2. Мөн төслийн төсөвт өртгийн 75% хүртэлх дүнтэй тэнцэх хэмжээний буюу их хэмжээний хэлцэл хийж, гадаад болон дотоодын иргэн, аж ахуйн нэгжээс хөрөнгө оруулалт авах, хамтран ажиллах эрхийг Төлөөлөн Удирдах зөвлөлд олгосугай.
3. Төлөөлөн Удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасны дагуу сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээ, тайланг эрх бүхий байгууллага, хөндлөнгийн аудитын байгууллагад цаг тухайд нь мэдэгдэж, хууль, журмыг чанд мөдөн ажиллахыг үүрэг болгосугай.
4. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн талаарх тайланг дараагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлд даалгасугай.

Даргалагчаас: Тогтоолуудаа гар өргөн батлая гэснээр хуралд оролцсон нийт гишүүд 100% гар өргөн батлав.

Даргалагчаас: Хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа. Хурал хаахаас өмнө хэлэх санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэснээр хурал 13 цаг 01 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ийн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХУРЛЫН ДАРГА



Т.ЛХАГВАЧУЛУУН

Д.ОЮУН